

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны  
12 дугаар сарын 27-ны өдрийн 11:00  
дугаар тушаалын хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан  
шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27 11:00

#### Байгууллагын нэр:

Мөрдөн байцаах алба

#### Нэгжийн нэр:

Тусгай субъектын үйлдсэн гэмт хэрэг мөрдөн  
шалгах хэлтэс

#### Албан тушаалын нэр:

Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга

#### Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-3

#### Ажлын цаг:

8 цаг

#### Ажлын байрны албан ёсны байршил:

Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,  
Самбуугийн гудамж-18

#### Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

#### Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гол түймэр, хүн, малын гоц  
халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад  
аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй  
байдал үссэн, террорист халдлага, онц  
болон дайны байдал зарласан, онц ноцтой  
гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй  
тохиолдолд уртасгасан цагаар болон  
өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

#### Албан тушаалын зорилго:

- Харьялуулсан чиглэлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлэх, тасгийн ажлыг  
зохион байгуулж, Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай  
хууль, Цагдаагийн албаны тухай, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Цагдаагийн байгууллагын  
гүйцэтгэх ажлын зааварт заасан үндэслэл журмын дагуу мөрдөн шалгах нууц ажиллагаа,  
гүйцэтгэх ажил явуулж, тасгийн чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн үндсэн дээр  
зохион байгуулж, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах.  
-Тасгийн алба хаагчдын ажлын үр дүн, аюулгүй байдлыг хангах, тэдний хууль ёсны ашиг  
сонирхлыг хамгаалж Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга болон Дотоод хяналт-аюулгүй  
байдлын газрын дарга, Мөрдөн байцаах албаны Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг  
мөрдөн шалгах хэлтсийн дарга наарт танилцуулах

- 1.Харьялуулсан гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц  
ажиллагаанд хяналт тавьж, тасгийн алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан  
зохион байгуулах.

2.Харьяаллын гэмт хэргийн нөхцөл байдал, гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагааны явц, үр дүнд үнэлэлт өгч, харьяаллын гэмт хэргийн баримтуулалт, хяналт шалгалтын явц байдлын талаар Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга болон Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дарга наарт тухай бүр танилцуулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хариуцан зохион байгуулах.

3.Гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох талаар цагдаагийн бусад албадтай хамтран ажиллах.

4.Удирдлагаас өгсөн бусад үүргийг хэрэгжүүлэх.

5.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах -Т, Харилцан, гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1.Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай болон Цагдаагийн албаны тухай хууль, холбогдох бусад журам, зааврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.</p> <p>1.2.Алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлж, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, мөрдөн шалгах ажиллагаа, гүйцэтгэх ажлыг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах.</p>	Мөрдөн шалгах ажлын үр дүн дээшилж, шийдвэрлэлт ахисан байна.	X, Ш Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1.Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлын заавар болон Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын хоёрдугаар бүлэгт заасан журмыг хэрэгжүүлэх,</p> <p>2.2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасныг хэрэгжүүлэх;</p> <p>2.3.“Гүйцэтгэх ажилтнуудад хөтлөх бүртгэл судалгааны жагсаалт”-д заасан бүртгэлүүдийг биечлэн хөтлөх, алба хаагчдын хөтлөлтөд хяналт тавих.</p> <p>2.4.Тасгийн гүйцэтгэх ажлын хэрэг, хэрэг бүртгэлийн хэрэг, маш нууц баримт бичиг, биет зүйлсийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, зөрчил дутагдаж илэрсэн тохиолдолд албаны шалгالت хийлгэж үр дүнг удирдлагад танилцуулах.</p> <p>2.5. Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын алба хаагчидтай холбоотой гомдол, мэдээлэл, гэмт хэргийн талаарх судалгаа, мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч нэгтгэн гэмт хэрэг, зөрчлийн талаарх цахим санг баяжуулж нэгтгэх.</p>	Гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах	X, Ш Г, Х, Ш Х, Ш Х

	<p>3.1.Хуулиар харьяалуулсан гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр гүйцэтгэх ажлын мөрдөн тагнах болон хэрэг бүртгэлтийн хэрэгт мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажил явуулах ажилд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангах.</p> <p>3.2.Хариуцсан чиглэлийн гэмт хэргийн улсын хэмжээний нөхцөл байдлын судалгаанд үнэлэлт өгч, мэдээллийн эх сурвалжийн сүлжээг өргөтгөх, зохион байгуулах ажлыг удирдан ажиллах.</p> <p>3.3.Олсон мэдээллийг “Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлын заавар”-ыг баримтлан шалгаж шийдвэрлэх ажилд хяналт тавих.</p> <p>3.4.Сэжигтэй этгээд, байр байгууламжид чиглүүлэн туслах хүч зохион байгуулах, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах ажлыг удирдан зохион байгуулах.</p> <p>3.5.Тасгийн алба хаагчдын долоо хоногийн төлөвлөгөөг батлан биелэлтийг тооцон, өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавина.</p> <p>3.6.Гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай мэдээлэл солилцох, энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэх чадавхыг дээшлүүлэх сургалтад хамрагдуулах ажлыг зохион байгуулна.</p> <p>3.7. Нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийн талаарх мэдээ, мэдээллийг Цагдаагийн байгууллагын бусад албатай хамтран ажиллах.</p>	Харьяалуулсан чиглэлийн нөхцөл байдлыг судалж, гэмт хэргийн талаар мэдээлэл олж баримтжуулан буруутай этгээдэд хуулиин хариуцлага хүлээлгэх	Г, Х Г, Х Г, Х Х Г, Х Г, Х Г, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	<p>4.1.Удирдлагаас өгсөн үүргийг цаг тухайд нь биелүүлж, үр дүн биелэлтийг танилцуулах;</p> <p>4.2.Цагдаагийн алба, газар, хэлтсийн дарга болон дэд даргын эзгүйд түүнийг орлон гүйцэтгэх үед гүйцэтгэх ажил эрхлэхээс бусад эрхийг хэрэгжүүлэх.</p>	Ажлын гүйцэтгэл сайжирна.	Г Г
Хууль тогтоомж, дүрэм журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	<p>5.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх;</p> <p>5.2.Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн шударга ёсыг эрхэмлэн, “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг чанд мөрдөх;</p> <p>5.3.Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.</p>	-	Г Г Г

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

<b>Боловсрол</b>	Дээд боловсролтой, бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.			
<b>Мэргэжил</b>	-Эрх зүй /0421/ -Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/			
<b>Мэргэшил</b>	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.			
<b>Туршлага</b>	Цагдаагийн байгууллагад 8-аас доошгүй жил, үүнээс харьяа нэгжийн болон албаны ахлах, түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх.			
<b>Ур чадвар</b>	Удирдан зохион байгуулах	-Хариуцсан нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэж, шаардлага тавьж чаддаг байх; -Удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдах; -Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх.		
	Дүн шинжилгээ хийх	-Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж, дүгнэх; -Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх.		
	Асуудал шийдвэрлэх	-Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх. -Ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дууриал үзүүлэх;		
	Манлайлах	-Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; -Байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгуулэн ойлгуулах, хэрэгжүүлэх.		
	Бусад	-Албан хэрэг хөтлөлт боловсруулах, монгол хэл, бичгийн дүрэм, үг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх. -Компьютерийн Microsoft Office Word, Microsoft Office Excel, Microsoft Office Power Point программуудыг хэрэглээний түвшинд ашиглах чадвартай байх. -Нууц хадгалах.		

### IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЬЕКТ

#### Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дарга, Мөрдөн байцаах албаны Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн дарга

**Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:**  
Батлагдсан орон тоо.

**Бусад харилцах субъект:**

**Шууд харилцах байгууллага:**

-Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доosh зэрэглэлтэй албан тушаалтан;

**Шууд бус харилцах байгууллага:**

-Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.

### V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

**Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:**

**Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:**

Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА

Т.ГАНЗОРИГ

2023 оны 12 дугаар сарын 21-ны өдөр

Байгууллагын нэр: .....

Шийдвэрийн огноо: .....

Дугаар:.....

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27-өдөр

Дугаар: .....

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.СҮХБОЛД

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

**ТАНИЛЦСАН:**

Албан тушаалтан: .....

.....

.....

20...оны .... дугаар сарын ....-ны өдөр